



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛ**

2022 оны 01 дугаар сарын 20

Дугаар 01

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 1 дүгээр хуралдааны тэмдэглэлд:

I.6.ХЭЛЭЛЦСЭН НЬ:

“Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрыг 2031 он хүртэлх хугацаанд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 2017-2021 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж дүгнэсэн тухай.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1.“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь 2017-2020 онд геологи хайгуулын ажлыг эрчимжүүлэх бодлогын хүрээнд хөрөнгө оруулалтыг эрс нэмэгдүүлж, Эрдэнэтийн овоо ордын хүдрийн нөөцийг өсгөн цаашид 60-70 жил ажиллах боломжийг бүрдүүлж, үйлдвэрийн тогтвортой хөгжлийн урт хугацааны бодлого, чиглэлийг тодорхойлж, ирээдүйд чиглэсэн томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхэлсэн, хөрс хуулалт, хүдэр боловсруулалт, баяжмал үйлдвэрлэл болон борлуулалтын орлого, цэвэр ашгийн хэмжээг тус хугацаанд тогтвортой хадгалаад зогсохгүй жил бүр нэмэгдүүлж, нэгж бүтээгдэхүүнд ногдох өртөг зардлыг бууруулж ажилласан, улс, орон нутгийн төсөвт таван жилийн дүнгээр 4.4 их наяд төгрөгийг төвлөрүүлэн, Коронавируст халдварт цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад 1.1 их наяд төгрөгийн дэмжлэг үзүүлэн ажилласныг сайшаасугай.

2.“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын 2017-2021 онд ажлын өндөр үр бүтээлтэй, идэвх зүтгэлтэй ажилласан уурхайчид, хамт олныг шагнаж урамшуулах тухай асуудлыг холбогдох дүрэм, журмын дагуу “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Ерөнхий захирлын бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэх нь зүйтэй гэв.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР



132002003